

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Дугаар 06

“А” Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр		Нэгжийн нэр	
Хонхор тосгоны эрүүл мэндийн төв		Эмнэлгийн тусламж үйлчилгээ	
Ажлын байрны нэр		Ангилал	Зэрэглэл
Эх барих бага эмч		Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харьяалагдах ажлын байр		Шууд харьяалах ажлын байр (албан тушаал)	
-Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга, Эмчлэгч эмч		Сувилагч, үйлчлэгч	
Ажлын байрны зорилго	Үйлчлэх хүрээний хүн амд эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай жигд хүртээмжтэй чанартай үзүүлэх		
Ажлын байрны үндсэн зорилт	1.Үйлчлэх хүрээний хүн амд гэр бүр төлөвлөлтийн тусламж үйлчилгээ үзүүлэх 2.Үйлчлэх хүрээний жирэмсэн эмэгтэй бүрт нэн шаардлагатай эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх 3.Үйлчлэх хүрээний хүн амд төрөх болон төрсний дараах үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх 4.Хүн амд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх 5. Үйлчлэх хүрээний хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх 6.Анхан шатны бүртгэл маягтыг хөтлөх 7.Өөрийн мэдлэг, мэргэжил, ур чадвараа тогтмол дээшлүүлэх, мэргэжлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг хөгжүүлэх, мэдлэг олгоход оролцох 8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд өөрийн ажлын байрны үйл ажиллагаанд чанарын гүйцэтгэлийг хариуцан ажиллах		

“Б” Ажлын байрны гол үйл ажиллагаа

Ажлын байрны гол үйл ажиллагаа	Хугацаа
Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:	
- Үйлчлэх хүрээний хүн амд гэр бүл төлөвлөлтийн доорх тусламж, үйлчилгээг батлагдсан журам, заавар, стандартын дагуу үзүүлнэ	-Тогтмол
-Үйлчлэх хүрээний хүн амд жирэмснээс сэргийлэх эм хэрэгслийн талаар мэдээлэл, зөвөлгөөг өгч сонголт хийлгэх, хэрэглүүлэх ажлыг хариуцна.	-Тогтмол
-Нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийн судалгааг нарийвчлан гаргаж жил бүр шинэчлэлт хийнэ.	-Тогтмол
-Хэсгийн ажлагч нартаа хамтран эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн судалгаа дээр үндэслэн ЖСА-г хэрэглэх арга техник зааж өгөх, нэн шаардлагатай иргэдэд тарааж өгч гарын үсгээр баталгаажуулна.	-Тогтмол

<u>Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</u> - Үйлчлэх хүрээний хүн амын дунд жирэмсэн эмэгтэйг эрт илрүүлж, хяналтад оруулна -Жирэмсэн үеийн эрсдлийг эрт илрүүлж, мэргэжлийн эмчид илгээнэ -Шаардлагатай шинжилгээг хийлгэж, үнэлгээ өгөх, шинжилгээнд өөрчлөлт гарсан жирэмсэн эмэгтэйг эмчид илгээж зөвөлгөө авах, эмчийн зөвөлгөөний дагуу эмэгтэйд эрүүл мэндийн тусламж үзүүлнэ -Хэвийн явцтай жирэмсний хяналтыг батлагдсан журам, заавар, стандартын дагуу бүрэн хийнэ. -Жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд нэн шаардлагатай аминдэм, төмрийн бэлдмэл, фолийн хүчил болон бусад элемент, үтрээний лааны жор бичиж хэрэглүүлнэ. -Жирэмсэн эмэгтэй, түүний гэр бүрийн гишүүнд сэдэв тус бүрээр нотолгоонд суурилсан мэдээлэл зөвөлгөө өгнө - Үйлчлэх хүрээний хүн амын жирэмсэн эмэгтэйд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эмчийн удирдлага дор тусламж үйлчилгээний нэн шаардлагатай болон нэмэлт багцын дагуу эмчилнэ.	-Тогтмол -Тогтмол -Тогтмол -Тогтмол -Тогтмол -Тогтмол -Тогтмол
<u>Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд:</u> -Төрсөн эхэд зөвөлгөө (ЖСА орчин үеийн аргууд, эрүүл ахуйн, халдвар хамгаалалт, хооллолт, дасгал хөдөлгөөн төрсний дараах сэтгэлзүй) өгнө. -Гэрийн эргэлтээр төрсөн эх, нярайг батлагдсан журам, заавар, стандартын дагуу тогтмол хянаана.	-Тогтмол -Тогтмол
<u>Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд:</u> - Үйлчлэх хүрээний хүн амд анхан шатны идэвхитэй үзлэг хяналт хийнэ -Яаралтай тусламж үзүүлж, дараагийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулна. -Олон улсын болон байгалийн голомтот халдварт өвчний үед жирэмсэн эмэгтэйд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангана. -Амь тэнссэн болон яаралтай онцгой, хойшлуулшгүй тохиолдолд эмнэлгийн нэн шаардлагатай тусламжийг үзүүлнэ -Гамшиг осол онцгой тохиолдолд шууд харьяалагдах болон дээд албан тушаалтны шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлнэ.	-Тогтмол -Тогтмол -Тогтмол -Тогтмол -Тогтмол
<u>Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд:</u> - Үйлчлэх хүрээний хүн амд умайн хүзүүний болон хөхний өмөнгөөс сэргийлэх талаар зөвөлгөө өгөх, хөхөө өөрөө шалгаж сурах талаар сургалт явуулж хэвшүүлнэ. -БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн сорил тавин, эерэг тохиолдолд эмчид илгээх, эмчийн зааврын дагуу эмчилнэ. -Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд сэтгэл заслын зөвөлгөө өгч, хаана хэнд хандах мэдээлэл өгнө. -Өсвөр үе, зорилтот бүлэг рүү чиглэсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар сургалт, сурталчилгааг хийнэ. -Эрсдэлт зан үйл, дадлыг (донтолт, ажил амьдралын нөхцөл, хүчирхийлэл) оношилно.	-Тогтмол -Тухай бүр -Тухай бүр -Тухай бүр -Тогтмол -Тогтмол

-Үргүйдэлтэй гэр бүлүүдэд анхан шатны чиглүүлэх зөвөлгөө өгөх, эмчид илгээнэ.	
<u>Ажлын байрны VI үндсэн зорилтын хүрээнд:</u> -Байгууллагаас төлөвлөгөөний дагуу сургалт, сурталчилгааны болон олон нийтийн ажилд оролцох -Байгууллагын ажилтан албан хэрэг хөтлөлтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 1. Байгууллагын үйл ажиллагааг холбогдох журам, стандартын дагуу баримтжуулах; 2. Баримт бичгийг боловсруулахад Монгол хэлний тухай хуулийн 8.1-д заасны дагуу монгол хэлний зөв бичих дүрмийг мөрдөх; 3. Баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах; 4. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгийг төрөлжүүлэн ангилах; 5. Баримт бичиг хянан шийдвэрлэхэд холбогдох хууль, журамд заасан хугацааг баримтлах; 6. Албан ажил үүрэгтэй холбогдсон баримт бичиг, мэдээллийн нууцлалыг хадгалах; 7. Баримт бичгийг байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй шилжүүлэх -Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх -Багаар ажиллах болон хөрвөн ажиллах	-Тогтмол -Тухай бүр -Тогтмол -Тогтмол

“В” Тавигдах шаардлага

1. Ажлын байранд тавигдах шаардлага	Эмнэл зүйн ур чадвар	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	-Дипломын буюу баклаврын боловсролын зэрэгтэй	
		Мэргэжил	-Эх баригч -“Эх барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	-Мэргэжлийн аль нэг зэрэгтэй байж болно
		Мэргэшил	-Мэргэшлийн сургалтад суралцсан байх	-Мэргэжлийн зэрэгтэй байж болно.
		Туршлага	-Тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээнээс шатлалаас хамаарч ажилласан жилийн шаардлага тавьж болно. -3 жил тутам мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдана.	-Шинэ мэргэжилтэнд зориулсанинэ мэргэжилтэнд зориулсан сургалтад хамрагдсан байх
		Гадаад хэл	-Англи хэлний зохио мэдлэгтэй	-Бусад гадаад хэлний мэдлэгтэй

	Компьютерийн мэдлэг	-Хэрэглээний программ ашиглах -Интернэтийн орчин, дотоод сүлжээнд ажиллах	-Ажил үүрэгтэй холбоотой программыг ашиглах
	Судалгааны арга зүй	-Статистик мэдлэг	-
	Бусад ур чадвар	-Тоног төхөөрөмжийг ажиллуулж чадах -Багаар ажиллах -Хувийн зохион байгуулалт, хувийн соёл, харилцааны чадвар -Шийдвэр гаргах	
	1.2.Тусгай шаардлага	-Төрийн албан хаагчийн болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах -Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх -Бусад тохиолдолд хөрвөн ажиллана.	

Г" Хүчин зүйлс

1.Ажлын байрны харилцах субъект		
1.1.Байгууллагын дотор талд: -Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга -Бусад их эмч, сувилагч, бусад ажилтан	1.2.Байгууллагын гадна талд: -Үйлчлүүлэгч, түүний ар гэр, асран хамгаалагч, ар гэрийнхэнтэй үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудлаар -Анагаах ухааны боловсрол олгох сургуулиуд, мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах	
2.Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн даргын өмнө хариуцна.	
3.Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1.Санхүүгийн:	-Үндсэн цалинг Засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох -Хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшил олгох
	3.2.Материалын	-Шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж -Ажлын байрны стандартыг хангасан өрөө, тавилга -Компьютер, дагалдах хэрэгслийн хамт -Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл -Дотуур холбоо, дотоод сүлжээ
	3.3.Хүний	-Эмч сувилагч, бусад ажилтантай хамтран ажиллах
	3.4.Бусад	-Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамрагдах

4.Ажлын байрны нөхцөл	Хэвийн
5.Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр	Шаардлагатай үед тасаг, амбулаторийн сувилагчийг орлон хавсарч ажиллах

“Д” Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан	Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
Хонхор тосгоны эрүүл мэндийн дарга <i>О. Оюуннасан</i> /эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр//Гарын үсэг/ 2025 оны 08 сарын 03-ны өдөр	Эх баригч <i>Д. Асмангуяа</i> /эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр//Гарын үсэг/ 2025 оны 08 сарын 03-ны өдөр

